



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 20 өдөр

Дугаар A/04

Батширээт сум

**Мод бэлтгэх үйл ажиллагааг
явуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 18.2.2, 18.2.7, 30.1, 30.2, Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын дэглэмийн 12.1, тавдугаар бүлгийн 15 дугаар зүйлийн 15.2, 16 дугаар зүйлийн 16.3, 16.5, Батширээт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 29 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 29 дүгээр тоот тогтоол, 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан хуваарийн дагуу ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөл, багийн иргэдийн мод бэлтгэлийн ажлыг 2026 оны 12 дугаар сарын 25-ны дотор хийлгэж дуусгаж ажиллахыг Батширээт Сум дундын Ойн ангийн дарга (Г.Гантуяа)-д зөвшөөрсүгэй.


2. Багийн иргэн, төсвийн байгууллагын албан хаагчдыг орон сууц болон шинээр хашаа, саравч барих, малчин өрхийг модоор хангах ажлыг хуваарийн дагуу бэлтгэж нийлүүлэх ажилд арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг ойн мэргэжлийн байгууллагын захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Ойн мэргэжлийн байгууллагууд нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх ажлыг 1-р хавсралтаар, Мод бэлтгэх байгууллага газрын нэрсийг 2-р хавсралтаар, Аж ахуйн нэгж, нөхөрлөлүүдийн ойжуулалт хийх төлөвлөгөөг 3-р хавсралтаар тус тус баталсугай.

4. Багийн иргэдийн уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон ахуйн хэрэглээний зорилгоор ойгоос мод бэлтгэх ажлыг оновчтой зохион байгуулахыг Багийн засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Мод бэлтгэлийн талбай тусгаарлалт, эхлэл дуусгаврын акт, хяналтын хуудас болон бусад холбогдох баримтыг хууль журмын дагуу бүрдүүлж, хөтлөх явцад хяналт тавьж ажиллахыг Сум дундын Ойн ангийн дарга Г.Гантуяа, ойг цэвэрлэх хүлээн авах, мод тээвэрлэлтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (Б.Мөнх-Очир), Байгаль хамгаалагч нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232601007